



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 1 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 2

Улаанбаатар  
хот

Газрын тос боловсруулах үйлдвэр барих  
төслийн талаар авах зарим арга  
хэмжээний тухай

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл<sup>1</sup>-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын Хөгжлийн банкны зээлээр сөнхүүжүүлэх талаар хэлэлцээ хийхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц Ням-Осор)-г зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын Хөгжлийн банкнаас "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид олгох зээл, зээлийн хүүг газрын тос боловсруулах үйлдвэр ажиллалтад орж, үйл ажиллагаа эхэлсэн үеэс тооцож төлөх талаар Монгол Улсын Хөгжлийн бангтай хэлэлцээ хийж, гэрээ байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц Ням-Осор)-г даалгасүгэй.

3. Төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалт (темер зам, автозам, цахилгаан дамжуулах шугам, үйлдвэрийн талбай)-ын ажлыг 2018 оны эхний хагас жилд багтаан эхлүүлэх арга хэмжээ авч, явц үр дүнгийн талаар Засгийн газарт тухай бүр танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц Ням-Осор)-т тус тус даалгасүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Сангийн сайд

Ч.ХҮРЭЛБААТАР